



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох журмыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
2025 оны 01 дүгээр сарын 01 ны өдрийн
01... дугаар тогтоолын хавсралт



**НЭРИЙН ДАНСЫГ НЭЭХ, БҮРТГЭХ, ХӨТЛӨХ, ДААТГУУЛАГЧИЙН
ГАРААНЫ ҮЛДЭГДЛИЙГ ТООЦОХТОЙ ХОЛБОГДСОН
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс (цаашид "нэрийн данс" гэх) нээх, гарааны үлдэгдэл тооцох, ажил олгогч, даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэл (цаашид "шимтгэл" гэх)-ийг бүртгэх, нэрийн дансанд тооцсон хүүг бүртгэх, нэрийн дансанд бүртгэсэн орлогын бодит мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хэсэг (цаашид "мөнгөжүүлсэн орлого" гэх)-ийг бүртгэх, хяналт, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Нэрийн данс нээх

2.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэгт заасны дагуу 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн, шимтгэл төлсөн даатгуулагчид нэрийн данс нээнэ.

Гурав. Нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцох

3.1.Нэрийн дансны гарааны үлдэгдлийг 2000 оноос өмнө ажил хөдөлмөр эрхэлсэн, албан журмаар эсхүл сайн дураар даатгуулж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчид тооцно. Гарааны үлдэгдэл нь даатгуулагчийн нэрийн данс нээлгэсэн эхний үлдэгдэл байна.

3.2.Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход дараах үзүүлэлтүүдийг харгалзана.Үүнд:

3.2.1.Даатгуулагчийн 1995 он хүртэл ажиллаж шимтгэл төлснөөр тооцох хугацаа;

3.2.2.Даатгуулагчийн 1995-1999 онд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, итгэлцүүрээр өсгөсөн 5 жилийн дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого (цаашид "цалин хөлс" гэх);

3.2.3.1995-1999 онд мөрдөж байсан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;

3.2.4.энэ журамд заасан гарааны үлдэгдэл тооцоход баримтлах 1995-1999 оны цалин хөлсний итгэлцүүр.

3.3.Нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцоход энэ журмын 3.2-т заасан

үзүүлэлтүүдийг харгалзан дараах томъёогоор бодно:

3.3.1.Нэрийн дансны гарааны үлдэгдэл:

$$Г_{с1}=(Б \times Ш_{сар}) * 96\%$$

Г_{с1}-нэрийн дансны гарааны үлдэгдэл;

Б-сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээ;

Ш_{сар}-2000 он хүртэл шимтгэл төлж, ажилласан нийт сарын тоо;

96%-Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 27.3.2, 27.3.3, 27.3.4, 27.3.5, 27.3.6-д заасан шимтгэлийн орлогоос 4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэснийг хассан хувь.

3.3.2.Сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээг доорх томъёогоор бодно:

$$Б = \frac{\sum_i^n Ц_i \times Д_i}{N} * 19\%$$

Ц_i-даатгуулагчийн 1995-1999 оны сарын цалин хөлсний хэмжээ;

Д_i-гарааны үлдэгдэл тооцоход баримтлах 1995-1999 оны итгэлцүүр;

19.0%-1995-1999 онд мөрдөж байсан тэтгэврийн даатгалын шимтгэл /ажил олгогч-13.5, даатгуулагч-5.5/-ийн хувь хэмжээ.

3.4. Энэхүү журмын 3.2.1-д заасан шимтгэл төлсөн хугацааг дараах байдлаар сараар тооцно. Үүнд:

3.4.1.Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө ажилласан хугацааг хөдөлмөрийн дэвтэр (тушаалын хуулбар, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр, цэргийн батлах, цэргийн байгууллагын архивын лавлагаа, 1991-1994 оны аж ахуйн нэгж, байгууллагын цалин хөлсний сангаас нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тодорхойлолт зэрэг)-ийг үндэслэнэ.

3.4.2.Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг нийгмийн даатгалын дэвтэр, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, шимтгэл төлөлтийн тооцооны хуудас, нийгмийн даатгалын байгууллагын архивын лавлагаа зэргийг үндэслэн тооцно.

3.5.Энэхүү журмын 3.2.2-т заасан сарын дундаж цалин хөлсний хэмжээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:



3.5.1. Даатгуулагчийн 1995-1999 онд шимтгэл төлж ажилласан 5 жилийн итгэлцүүрээр өсгөсөн цалин хөлсний нийлбэрийг шимтгэл төлсөн сарын тоонд нь хувааж дундаж цалин хөлсний хэмжээг тооцно.

3.5.2. Даатгуулагчийн нэрийн дансны гарааны үлдэгдлийг тооцох итгэлцүүрээр өсгөсөн сарын цалин хөлсний дээд хэмжээ нь 1999 онд мөрдөж байсан даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээ (425000 төгрөг)-нээс хэтрэхгүй байна.

3.5.3. 1995 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө ажилласан боловч 1995 оноос 2000 хүртэлх хугацаанд шимтгэл төлөөгүй даатгуулагчийн сарын дундаж цалин хөлсийг Засгийн газрын тогтоосон 1999 онд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (12000 төгрөгөөр)-гээр тооцно.

3.6. Энэ журмын 3.2.4-т заасан гарааны үлдэгдэл тооцоход баримтлах цалин хөлсийг өсгөн тооцоход баримтлах итгэлцүүрийн хэмжээ:

| № | Он | Нэрийн дансны итгэлцүүр |
|---|------|-------------------------|
| 1 | 1995 | 10.06 |
| 2 | 1996 | 4.60 |
| 3 | 1997 | 3.83 |
| 4 | 1998 | 3.54 |
| 5 | 1999 | 3.22 |

Дөрөв. Нэрийн дансны орлого бүртгэх, хөтлөх

4.1. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд нэрийн дансны орлогыг дараах байдлаар бүртгэж, хөтөлнө. Үүнд:

4.1.1. Даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу 2024 он хүртэл тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байхаар сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг баримтлан нийгмийн даатгалын байгууллага мэдээллийн нэгдсэн санд тухай бүр;

4.1.2. Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18.1 дэх хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцон нийгмийн даатгалын байгууллага даатгуулагч тус бүрээр мэдээллийн нэгдсэн санд тухай бүр;

4.1.3. Нийгмийн даатгалын холбогдох сангаас тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд тухай бүр;

4.1.4. Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 63.3 дахь хэсэгт заасан ажилтны шимтгэлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр даатгуулагч тус бүрээр тухай бүр;



4.1.5. Төрөөс төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг холбогдох журмын дагуу баталгаажуулан даатгуулагч тус бүрээр тухай бүр;

4.1.6. Энэхүү журмын 5.1-д заасан хүүгийн орлогыг даатгуулагч тус бүрээр нэрийн дансанд нь нийгмийн даатгалын байгууллага жилд нэг удаа;

4.1.7. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш албан журмаар даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны амралттай, гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг ажил олгогч нь хариуцан төлж байгаа тохиолдолд тухайн даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаан дээр дараах орлогыг нэмж бүртгэнэ:

4.1.7.1. Албан журмаар даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны амралттай, гурав хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны нэрийн дансны орлогыг жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодуулсан сүүлийн 12 сарын цалин хөлсний дунджаас ажил олгогч, даатгуулагчийн төлбөл зохих шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдийг 3 нас хүртэл хүүхэд асрах чөлөө дуустал сар бүр нэрийн дансанд нь бүртгэнэ.

4.2. Энэ журмын 4.1.1-4.1.5 дахь хэсэгт заасан тухайн жилийн тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнгээс мөнгөжүүлсэн орлого, илүү төлсөн шимтгэлийн буцаан олгох дүнг хассан дүнгээс хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэсэн 4 хувийг хасаж бүртгэнэ.

4.3. Энэ журмын 4.1.7, 4.5 дахь хэсэгт заасан орлогоос хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэсэн 4 хувийг хассан дүнгээр нэрийн дансанд бүртгэнэ.

4.4. Даатгуулагчийн давхар ажил эрхлэн хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс илүү төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хассан дүнгээр бүртгэнэ.

4.5. Даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргах үед дараах орлогыг нэрийн дансны орлогод нэмж бүртгэнэ:

4.5.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн 1995 оноос өмнө цэргийн алба хаасан хугацаанд ногдох шимтгэлийг даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр дараах орлогоос тооцож нэрийн дансанд нь бүртгэнэ:

4.5.1.1.Цэргийн алба хаасан хугацааны цалин хөлсөнд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэсэн дүнгээс тооцно;

Санамж:Итгэлцүүрээр өсгөсөн цалин хөлсийг тодорхойлохдоо Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 19.4 дэх хэсэг, Засгийн газрын холбогдох тогтоолыг баримтална.

4.5.1.2.Цэргийн алба хаасан хугацааг өсгөн тооцсон хугацааны шимтгэлийг тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож бүртгэнэ.

4.5.2.Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн, төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авсан хүүхдээ зургаан нас хүртэл өсгөсөн эхийн төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар тооцсон хугацааг тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь нэг удаа бүртгэнэ;

4.5.3.Хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байсан хугацааны шимтгэлийг өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нэрийн дансанд нь нэг удаа бүртгэнэ;

4.5.4.Нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг хөрөнгө оруулалтын өгөөжийн хамт нэрийн дансанд бүртгэнэ.

4.6.Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд тэтгэвэр тогтоолгохоос өмнө бүртгэсэн нэрийн дансны орлогоос тусад нь дараах байдлаар бүртгэнэ:

4.6.1.Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосноос хойш тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийг энэ журмын 4.1.1, 4.1.2 дахь хэсэгт заасны дагуу бүртгэнэ;

4.6.2.Энэ журмын 4.7 дахь хэсэгт заасан орлогоос мөнгөжүүлсэн орлогыг хасахгүйгээр зөвхөн хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэсэн 4 хувийг хассан дүнгээр бүртгэнэ.

4.7.Нэрийн дансны зарлагын бүртгэлийг нийгмийн даатгалын байгууллага дараах байдлаар бүртгэнэ:

4.7.1.Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэвэр

бодуулсан нэрийн дансны үлдэгдлээс сар бүр олгосон тэтгэврийн хэмжээгээр тухай бүр хасаж бүртгэнэ;

4.7.2.Энэ журмын 4.6 дахь хэсэгт заасан орлогоор тэтгэвэрт өөрчлөн тогтоолт хийлгэвэл тэтгэврийн өөрчлөгдсөн дүнгээр хасаж бүртгэнэ;

4.7.3.Нийгмийн даатгалын тайлангийн залруулга хийсэнтэй холбоотойгоор даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ буурсан бол буурсан орлогоос тооцсон тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого тухайн хугацааны өмнө тайлагнасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлогын зөрүүг хасаж бүртгэнэ.

Тав. Нэрийн дансны орлогод хүү тооцох

5.1.Даатгуулагчийн тухайн жилийн тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнгээс мөнгөжүүлсэн орлого, илүү төлсөн шимтгэлийн буцаан олгох дүнг хассан дүнгээс хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох зориулалтаар тусгайлан бүртгэсэн 4 хувийг хасаж тухайн жилийн нэрийн дансанд бүртгэгдсэн шимтгэлийн орлогод хүү тооцно.

5.2.Нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$\begin{cases} X = A * И + Б * Д \\ A + Б = 1 \end{cases}$$

X-тухайн онд нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээ;

И-өмнөх оны инфляцын түвшин;

Д-Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.1.20 дахь хэсэгт заасан арилжааны банкнаас албан ёсоор зарласан иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээ;

А-инфляцын түвшингээс сонгох хувь хэмжээ;

Б-иргэдийн мөнгөн хадгаламжийн өмнөх оны жилийн дундаж хүүгийн хэмжээнээс сонгох хувь хэмжээ.

Зургаа. Нэрийн дансны эцсийн үлдэгдэл тооцох

6.1.Даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг дараах томъёогоор тооцно:

$$НД_{с2} = (НД_{с1} + БШО) \times (100\% + X_0)$$

НД_{с2}-нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;

НД_{с1}-нэрийн дансны тухайн жилийн эхний үлдэгдэл;



БШО-тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлого;

Х₀- тухайн жилийн нэрийн дансанд тооцсон хүүгийн хэмжээ

6.2. Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох нэрийн дансны эцсийн үлдэгдлийг дараах томъёогоор тооцно:

$$НД_{с2с2} = НД_{с2} + М + М_ө + НД_{тн}$$

НД_{с2с2} -тэтгэвэр тогтоолгох нэрийн дансны эцсийн үлдэгдэл;

НД_{с2}-нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл;

М-мөнгөжүүлсэн орлого;

М_ө-мөнгөжүүлсэн орлогын хөрөнгө оруулалтын өгөөж;

НД_{тн}-нэрийн дансны орлогын тусгай нөхцөл (энэ журмын 4.5 дахь хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргах үеийн нэрийн дансны тусгай нөхцөлийн дагуу тооцсон орлого)

Долоо. Хяналт

7.1. Энэ журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллагуудын холбогдох чиг үүрэг бүхий нэгж, нийгмийн даатгалын болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч хяналт тавина.

Найм. Хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

